**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ӨМА-2026/032/НА-СТА-ТШЗ**


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Даланзадгад хот<br>2026 он | Дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр<br>Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: Т.Хонгорзул<br>Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn<br><br>Ахлах аудитор: Г.Шижирболд<br>Утас: 70533552 Цахим хаяг: shijirboldg@audit.gov.mn<br><br>Аудитор:О.Чойдорж<br>Утас: 70533552 Цахим хаяг: choidorjo@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.......3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.......5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.......5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.......6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.......7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.......9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.......9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.......10
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.......11
3.1 Албан шаардлага.......12
3.2 Зөвлөмж.......12
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.......14
Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл.......14
Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл.......16

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2026.02.25 № 247

танай ______________-ны №______________ -т

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БАЯН-ОВОО
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Ц.НАРАНТУЯА
ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Дээд шатны төсвийн захирагчаас автомашинд шаардлагатай урсгал засвар хийхэд олгосон 41,631.9 мянган төгрөгийн төсөвт өртгийг хувааж шууд худалдан авалт хийсэн, үзүүлсэн ажил, үйлчилгээ тодорхойгүй, анхан шатны бүрдэл дутуу баримтаар 8,340.0 мянган төгрөг зарцуулсан нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 13 дугаар зүйлийн 13.7, 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Говийн оюу хөгжлийг дэмжих сангаас баяр наадам зохион байгуулахад 10,000.0 мянга, тэмээний баярын арга хэмжээнд 3,000.0 мянган төгрөг хандивласан байна.

4626050391

F:\2.Бичиг хэрэг\2026он\СТА-н дүгнэлт\Төсөл.Docx

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд 3,522,957.7 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 1,729,583.1 мянган төгрөг зарцуулсан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 834,810.2 мянган төгрөг, Говийн оюу хөгжлийг дэмжих сангаас 72,339.2 мянган төгрөг, аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 547,943.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нийлүүлэгдсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ӨСӨХБАЯР

F:\2.Бичиг хэрэг\2026он\СТА-н дүгнэлт\Төсөл.Docx

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*(төгрөгөөр)*

| Дансны код | Балансын зүйл | Тодруулга | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|---|
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 4 | - | - |
| 311 | Кассанд байгаа бэлэн мөнгө | | - | - |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | | - | - |
| 31400 | Замд яваа мөнгөн хөрөнгө | | | |
| 33 | АВЛАГА | 5 | 34,797,600.00 | 21,850,000.00 |
| 335 | Бусад авлага | | 34,797,600.00 | 21,850,000.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | | - | 7,000,000.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | | 34,797,600.00 | 14,850,000.00 |
| 34 | УРЬДЧИЛГАА | | - | - |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 6 | 533,065,383.00 | 866,751,348.40 |
| 354 | Хангамжийн материал | | 528,431,751.00 | 857,217,716.40 |
| 35410 | Бичиг хэргийн материал | | 2,559,379.00 | 4,007,379.00 |
| 35420 | Аж ахуйн материал | | 16,241,202.00 | 23,067,900.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | | 2,327,100.00 | 1,737,500.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | | - | - |
| 35450 | Барилгын засварын материал | | 31,165,000.00 | 20,835,000.00 |
| 35460 | Хүнсний материал | | | |
| 35470 | Бусад хангамжийн материал | | 476,139,070.00 | 807,569,937.40 |
| 35500 | Биологийн хөрөнгө | | | |
| 35600 | Мал амьтад | | 4,633,632.00 | 9,533,632.00 |
| 36 | НӨӨЦИЙН БАРАА | | - | 33,300,000.00 |
| 36300 | Тэжээлийн нөөц | | - | 33,300,000.00 |
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | | 567,862,983.00 | 921,901,348.40 |
| 37 | УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ | | - | - |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | | 11,974,716,134.49 | 12,460,271,863.68 |
| 392 | Биет хөрөнгө | | 11,900,086,134.61 | 12,385,841,863.68 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | | 4,981,705,660.98 | 5,035,268,940.98 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | | (1,245,573,969.49) | (1,415,709,184.93) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | | 557,664,800.00 | 622,824,800.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | | (183,957,466.68) | (283,506,133.64) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | | 651,537,274.00 | 641,660,172.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | | (199,733,500.60) | (205,858,377.43) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | | 211,733,213.00 | 325,040,602.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | | (92,571,560.45) | (64,958,507.77) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | | 7,729,632,934.00 | 8,859,438,885.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | | (1,178,469,056.41) | (1,732,618,673.35) |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | | 11,802,100.00 | 11,802,100.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | | 706,057,893.50 | 722,014,274.50 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | | (49,742,187.24) | (129,557,033.68) |
| 393 | Биет бус хөрөнгө | | 74,629,999.88 | 74,430,000.00 |
| 39301 | Програм хангамж | | 1,040,000.00 | 1,040,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | | (840,000.12) | (1,040,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | | 74,430,000.00 | 74,430,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | | 11,974,716,134.49 | 12,460,271,863.68 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | | 12,542,579,117.49 | 13,382,173,212.08 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 9 | 44,097,700.00 | 71,242,765.48 |
| 413 | Өглөг | | 44,097,700.00 | 71,242,765.48 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | | - | 3,545,800.00 |
| 41340 | Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг | | - | 20,000,000.00 |
| 4136 | Бусад өглөг | | 44,097,700.00 | 47,696,965.48 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | | 44,097,700.00 | 47,696,965.48 |
| 414 | Урьдчилж орсон орлого | | - | - |
| 42 | УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | | - | - |
| 422 | Урт хугацаат зээл | | - | - |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | | 44,097,700.00 | 71,242,765.48 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | | 12,498,481,417.49 | 13,310,930,446.60 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | | 945,495,595.96 | 945,495,595.96 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 51101 | Өмч: - төрийн | | 945,495,595.96 | 945,495,595.96 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | | 11,351,519,319.54 | 12,163,968,348.65 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | | 11,351,519,319.54 | 11,351,519,319.54 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | - | 812,449,029.11 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | | 201,466,501.99 | 201,466,501.99 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | | 12,498,481,417.49 | 13,310,930,446.60 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | | 12,542,579,117.49 | 13,382,173,212.08 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*(төгрөгөөр)*

| Дансны код | Үзүүлэлт | Тодруулга | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|---|
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | | 2,154,824,918.00 | 2,403,159,820.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | | - | - |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | 192,015,918.00 | 217,120,588.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 180,356,489.00 | 186,312,748.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 9,629,429.00 | 2,657,840.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 2,030,000.00 | 28,150,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | | 1,962,809,000.00 | 2,186,039,232.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | | 1,962,809,000.00 | 2,186,039,232.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | | - | - |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | | 1,998,341,409.00 | 2,115,048,663.40 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | | 1,998,341,409.00 | 2,115,048,663.40 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | | - | 117,385,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | | - | 117,385,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | | 1,434,295,047.00 | 1,455,123,379.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | | 564,046,362.00 | 542,540,287.40 |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 2 | 4,153,166,327.00 | 4,518,208,483.40 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | | 3,226,372,475.85 | 3,697,598,189.17 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 2,825,103,906.84 | 3,162,977,700.32 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | 603,298,702.65 | 840,499,972.25 |
| 210101 | Үндсэн цалин | | 297,331,891.65 | 322,602,950.31 |
| 210102 | Нэмэгдэл | | 229,862,057.00 | 369,107,595.84 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 16,271,702.00 | 45,189,959.00 |
| 210104 | Урамшуулал | | 41,985,106.00 | 92,067,535.70 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | 17,847,946.00 | 11,531,931.40 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 75,845,003.68 | 107,253,929.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 50,156,558.64 | 71,059,536.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | | 6,304,785.01 | 9,048,856.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | | 3,171,779.51 | 4,521,905.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | | 3,207,591.50 | 4,526,021.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | | 13,004,289.02 | 18,097,611.00 |
| 210206 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | | | |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | | 71,172,524.66 | 87,637,239.78 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | | 10,205,098.77 | 14,932,666.28 |
| 210302 | Түлш, халаалт | | 55,147,075.50 | 59,959,443.50 |
| 210303 | Цэвэр, бохир ус | | 5,820,350.39 | 12,745,130.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | 361,003,089.00 | 290,012,169.29 |
| 210401 | Бичиг хэрэг | | 7,095,200.00 | 21,460,340.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 66,669,753.00 | 72,553,538.69 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | 9,775,336.00 | 11,224,778.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,200,000.00 | 156,112,290.60 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,936,300.00 | 28,661,222.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 270,326,500.00 | - |
| 2105 | Нормативт зардал | - | - |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 20,290,000.00 | 78,037,350.00 |
| 210604 | Урсгал засвар | 20,290,000.00 | 78,037,350.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 18,762,000.00 | 21,660,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 18,762,000.00 | 21,660,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 104,924,325.00 | 206,148,388.31 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 103,445,325.00 | 201,743,388.31 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,479,000.00 | 4,405,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,569,808,261.85 | 1,531,728,651.69 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 687,757,014.00 | 390,132,990.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 860,400.00 | 9,241,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 881,190,847.85 | 1,132,354,661.69 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 401,268,569.01 | 534,620,488.85 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 85,720,041.00 | 77,961,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 12,870,000.00 | 17,495,900.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 15,463,300.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 13,858,721.00 | 16,930,300.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 58,991,320.00 | 28,071,500.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 315,547,085.64 | 456,456,073.85 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 315,547,085.64 | 456,456,073.85 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 1,442.37 | 203,415.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,442.37 | 203,415.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | - | - |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | - | - |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 3 3,226,372,475.85 | 3,697,598,189.17 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 926,793,851.15 | 820,610,294.23 |
| 145 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | - | - |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | - | 8,161,265.12 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 8,161,265.12 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | - | (8,161,265.12) |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 926,793,851.15 | 812,449,029.11 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*(төгрөгөөр)*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 2,207,068,818.00 | 2,403,159,820.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | - | - |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | - | - |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | - | - |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 2,207,068,818.00 | 2,403,159,820.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | - | - |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 244,259,818.00 | 217,120,588.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 180,356,489.00 | 186,312,748.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 9,629,429.00 | 2,657,840.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 54,273,900.00 | 28,150,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 1,962,809,000.00 | 2,186,039,232.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 1,962,809,000.00 | 2,186,039,232.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | - | - |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 1,922,607,728.00 | 2,329,596,540.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,922,607,728.00 | 2,329,596,540.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,521,339,158.99 | 1,787,976,051.15 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 603,298,702.65 | 840,499,972.25 |
| 210101 | Үндсэн цалин | 286,479,980.65 | 318,302,950.31 |
| 210102 | Нэмэгдэл | 230,605,727.00 | 375,943,435.54 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 16,271,702.00 | 45,189,959.00 |
| 210104 | Урамшуулал | 52,837,017.00 | 89,531,696.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 17,104,276.00 | 11,531,931.40 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 75,845,003.68 | 107,253,929.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 50,156,558.64 | 71,059,536.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,304,785.01 | 9,048,856.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,171,779.51 | 4,521,905.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,207,591.50 | 4,526,021.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 13,004,289.02 | 18,097,611.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 71,172,524.66 | 87,637,239.78 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 10,205,098.77 | 14,932,666.28 |
| 210302 | Түлш, халаалт | 55,147,075.50 | 59,959,443.50 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,820,350.39 | 12,745,130.00 |
| 210304 | Байрны түрээс | | |
| 210305 | Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/ | | |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 85,823,189.00 | 246,418,699.12 |
| 210401 | Бичиг хэрэг | 7,095,200.00 | 15,847,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 61,816,353.00 | 71,587,996.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 9,775,336.00 | 11,224,778.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,200,000.00 | 135,265,325.12 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,936,300.00 | 12,493,000.00 |
| 2105 | Нормативт зардал | - | - |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 14,490,000.00 | 77,967,750.00 |
| 210604 | Урсгал засвар | 14,490,000.00 | 77,967,750.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 18,762,000.00 | 19,110,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 18,762,000.00 | 19,110,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 118,466,325.00 | 219,197,989.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 116,987,325.00 | 214,792,989.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,479,000.00 | 4,405,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 533,481,414.00 | 189,890,472.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 532,621,014.00 | 180,679,472.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 860,400.00 | 9,211,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 401,268,569.01 | 541,620,488.85 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 85,720,041.00 | 77,961,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 12,870,000.00 | 17,495,900.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 15,463,300.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 13,858,721.00 | 16,930,300.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 58,991,320.00 | 28,071,500.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 315,547,085.64 | 456,456,073.85 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 315,547,085.64 | 456,456,073.85 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 1,442.37 | 7,203,415.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,442.37 | 7,203,415.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 284,461,090.00 | 73,563,280.00 |
| | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 4 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4) | - | - |

| | | | |
|---|---|---|---|
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 284,461,090.00 | 73,563,280.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 284,461,090.00 | 73,563,280.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 284,461,090.00 | 73,563,280.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | - | 20,000,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 284,461,090.00 | 53,563,280.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | (284,461,090.00) | (73,563,280.00) |
| 14 | Бусад эх үүсвэр | - | - |
| 25 | Санхүүгийн үйл ажиллагааны зардал | - | - |
| 7 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | - | - |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*(төгрөгөөр)*

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| 20.. оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 945,495,595.96 | 201,466,501.99 | 11,351,519,319.54 | 12,498,481,417.49 |
| 20.. оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 945,495,595.96 | 201,466,501.99 | 11,351,519,319.54 | 12,498,481,417.49 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 945,495,595.96 | 201,466,501.99 | 11,351,519,319.54 | 12,498,481,417.49 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 812,449,029.11 | 812,449,029.11 |
| 20.. оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 945,495,595.96 | 201,466,501.99 | 12,163,968,348.65 | 13,310,930,446.60 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*(төгрөгөөр)*

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 3,522,957,700.00 | 1,729,583,158.15 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | - | - |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 3,522,957,700.00 | 1,729,583,158.15 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 3,522,957,700.00 | 1,729,583,158.15 |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН | 3,522,957,700.00 | 1,729,583,158.15 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 3,522,957,700.00 | 1,729,583,158.15 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,037,150,600.00 | 1,656,019,878.15 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,928,261,000.00 | 1,578,058,878.15 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 826,506,600.00 | 762,806,732.25 |
| 210101 | Үндсэн цалин | 345,570,200.00 | 318,302,950.31 |
| 210102 | Нэмэгдэл | 382,469,200.00 | 368,508,935.54 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 55,500,000.00 | 45,189,959.00 |
| 210104 | Урамшуулал | 25,500,000.00 | 19,272,956.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 17,467,200.00 | 11,531,931.40 |

| | | | |
|---|---|---|---|
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 103,313,300.00 | 97,703,618.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 70,252,900.00 | 64,643,218.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,265,100.00 | 8,265,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,132,600.00 | 4,132,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,132,600.00 | 4,132,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 16,530,100.00 | 16,530,100.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 110,879,600.00 | 87,637,239.78 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 15,800,000.00 | 14,932,666.28 |
| 210302 | Түлш, халаалт | 79,879,600.00 | 59,959,443.50 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 15,200,000.00 | 12,745,130.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 285,721,400.00 | 245,729,099.12 |
| 210401 | Бичиг хэрэг | 19,647,100.00 | 15,847,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 83,400,000.00 | 70,898,396.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 11,300,100.00 | 11,224,778.00 |
| 210404 | Ном, хэвлэл | | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 157,667,800.00 | 135,265,325.12 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 13,706,400.00 | 12,493,000.00 |
| 2105 | Нормативт зардал | - | - |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 41,600,000.00 | 36,335,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 41,600,000.00 | 36,335,800.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 35,040,000.00 | 18,260,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 35,040,000.00 | 18,260,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 313,875,000.00 | 206,147,989.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 304,875,000.00 | 201,742,989.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 9,000,000.00 | 4,405,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 211,325,100.00 | 123,438,400.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 196,400,000.00 | 115,477,400.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 14,925,100.00 | 7,961,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 108,889,600.00 | 77,961,000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 108,889,600.00 | 77,961,000.00 |
| 213205 | Тэрээс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 17,495,900.00 | 17,495,900.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 15,463,300.00 | 15,463,300.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 16,930,300.00 | 16,930,300.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 59,000,100.00 | 28,071,500.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 1,485,807,100.00 | 73,563,280.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 1,485,807,100.00 | 73,563,280.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 1,485,807,100.00 | 73,563,280.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН | 3,522,957,700.00 | 1,729,583,158.15 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | - |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | - |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*(Төгрөгөөр)*

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| 1 | ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 217,120,588.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 217,120,588.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 186,312,748.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,657,840.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 28,150,000.00 |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН | 217,120,588.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 217,120,588.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 209,917,173.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 77,693,240.00 |
| 210101 | Үндсэн цалин | - |
| 210102 | Нэмэгдэл | 7,434,500.00 |

| | | |
|---|---|---|
| 210104 | Урамшуулал | 70,258,740.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 9,550,311.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 6,416,318.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 783,756.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 389,305.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 393,421.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,567,511.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | - |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 689,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 689,600.00 |
| 2105 | Нормативт зардал | - |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 41,631,950.00 |
| 210604 | Урсгал засвар | 41,631,950.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 850,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 850,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 13,050,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 13,050,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 66,452,072.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 65,202,072.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,250,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 7,203,415.00 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 7,203,415.00 |
| 213503 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | 7,203,415.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | - |
| 2 | НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН | 217,120,588.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 673,158.2 мянган төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 673,158.2 мянган төгрөгийн алдааг залруулж ажилласан. Үүнд:

- 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тайлангийн тодруулгыг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан "Санхүүгийн тайлангийн маягт"-ийн дагуу бэлтгээгүй
- Санхүүгийн байдлын тайлангийн үндсэн хөрөнгийн дүнг үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн эцсийн үлдэгдэлтэй тулган баталгаажуулахад 45.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан
- Бараа материалын тодруулга тайлангийн бусдаар авсан дүнг санхүүгийн үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалын дүнтэй тулган баталгаажуулахад 297,963.2 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд бараа үйлчилгээний бусад зардлыг 20,000.0 мянган төгрөгөөр илүү, бусад хөрөнгийн зардлыг 20,000.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан
- Үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн дүнг санхүүгийн үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийн дүнтэй тулган баталгаажуулахад 272,020.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан
- Бараа материалын тодруулга тайлангийн сэлбэг хэрэгслийн гүйлгээг нярвын уг тайлангийн гүйлгээтэй тулган баталгаажуулахад 3 дугаар сард 110.0 мянган төгрөг, 8 дугаар сард 1,280.0 мянган төгрөгийн орлого, зарлагыг дутуу тайлагнасан, тэжээлийн нөөцийн 2 дугаар сарын орлого 46,350.0 мянган төгрөгийн тусгаагүй тайлагнасан
- Нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайланд 7,000.0 мянган төгрөгийн орлого, төвлөрүүлэх шилжүүлгийг тус тус тусгаагүй тайлагнасан

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Аудитаар нийт 312,155.5 мянган төгрөгийн 7 зөрчил[2] илэрснээс 65,589.9 мянган төгрөгийн 5 зөрчилд албан шаардлага, 246,565.6 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өгсөн.

**3.1 Албан шаардлага**

1. Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 5,000.0 мянган төгрөг, бусад нийтлэг ажил үйлчилгээ төлбөр хураамжийн зардлаас 2,560.0 мянган төгрөг, мэдээллийн технологийн үйлчилгээний зардлаас 1,050.0 мянган төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийн зардлаас 396.0 мянган төгрөг, мөн барилгын засварын материал худалдан авахад 680.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлаас худалдан авахад 532.0 мянган төгрөгийг зарцуулж төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг зөрчсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 6.5.5-д "*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*", Сангийн сайдын 2026 оны "Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай" 112 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал"-тай тус тус нийцэхгүй байна.

2. Үзүүлсэн ажил, үйлчилгээ тодорхойгүй, анхан шатны баримтын бүрдэл хангагдаагүй байхад 8,340.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т ""*анхан шатны баримт" гэж ажил гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог*", 13 дугаар зүйлийн 13.7-д "*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*", гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.

3. Дээд шатны төсвийн захирагчаас автомашинд шаардлагатай урсгал засвар хийхэд зориулан олгосон 41,631.9 мянган төгрөгийн төсөвт өртгийг хувааж шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "*Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно*" гэж заасантай нийцэхгүй байна.

4. Бараа үйлчилгээний бусад зардлаас Түмэн тэмээний баярын арга хэмжээний медаль хийлгэхэд 3,000.0 мянган төгрөгийг нэхэмжлэх үндэслэн шилжүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т *"анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг сэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог",* 13 дугаар зүйлийн 13.7-д *"Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"* гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.

5. Тайлант онд 2,400.0 мянган төгрөгийн вирусийн программ худалдан авахдаа тус чиглэлээр үйл ажиллагаа явуулдаггүй аж ахуй нэгжээс худалдан авалт хийсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"* гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

**3.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Өглөг

***<u>Илрүүлэлт</u>:1*** Тайлант хугацаанд нийт 64,242.8 мянган төгрөгийн өглөгтэй тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

---

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

*<u>Өгсөн зөвлөмж</u>*: Төсвийн хөрөнгийг зохистой удирдаж өглөг үүсгэхгүй ажиллах

2. Үндсэн хөрөнгө

***<u>Илрүүлэлт</u>*:2** Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдлийг тулгахад ашиглалтын хугацаа дууссан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн нийт 22 нэр төрлийн 38 ширхэг 182,322.8 мянган төгрөгийн үлдэх өртөггүй хөрөнгө байна.

Энэ нь УСНББОУС 17 "Үндсэн хөрөнгө", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль 31 дүгээр зүйлийн 31.3.2-д "*илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох*" гэж заасантай нийцэхгүй байна.

*<u>Өгсөн зөвлөмж</u>*: Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхөн хөрөнгүүдийг жагсаалтыг гаргаж цаашид хэрхэн шийдвэрлэх саналыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлөөрөө хэлэлцүүлж, саналаа аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлж шийдвэрлүүлэх, үлдэх өртөггүй хөрөнгө ашиглахгүй байх,

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

*(мянган төгрөг)*

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тайлангийн тодруулгыг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан "Санхүүгийн тайлангийн маягт"-ийн дагуу бэлтгээгүй | 1 | - | | | 1 | - | 1 | - | | | | |
| Санхүүгийн байдлын тайлангийн үндсэн хөрөнгийн дүнг үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн эцсийн үлдэгдэлтэй тулган баталгаажуулахад 45.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан | 1 | 45.0 | | | 1 | 45.0 | 1 | 45.0 | | | | |
| Бараа материалын тодруулга тайлангийн бусдаар авсан дүнг санхүүгийн үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалын дүнтэй тулган баталгаажуулахад 297,963.2 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан | 1 | 297,963.2 | | | 1 | 297,963.2 | 1 | 297,963.2 | | | | |
| Төсвийн гүйцэтгэлийн тайланд бараа үйлчилгээний бусад зардлыг 20,000.0 мянган төгрөгөөр илүү, бусад хөрөнгийн зардлыг 20,000.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан | 1 | 40,000.0 | | | 1 | 40,000.0 | 1 | 40,000.0 | | | | |
| Үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн дүнг санхүүгийн үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийн дүнтэй тулган баталгаажуулахад 272,020.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан | 1 | 272,020.0 | | | 1 | 272,020.0 | 1 | 272,020.0 | | | | |
| Бараа материалын тодруулга тайлангийн сэлбэг хэрэгслийн гүйлгээг нярвын уг тайлангийн гүйлгээтэй тулган баталгаажуулахад 3 дугаар сард 110.0 мянган төгрөг, 8 дугаар сард 1,280.0 мянган төгрөгийн орлого, зарлагыг дутуу тайлагнасан, тэжээлийн нөөцийн 2 дугаар сарын орлого 46,350.0 мянган төгрөгийн тусгаагүй тайлагнасан | 1 | 49,130.0 | | | 1 | 49,130.0 | 1 | 49,130.0 | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайланд 7,000.0 мянган төгрөгийн орлого, төвлөрүүлэх шилжүүлгийг тус тус тусгаагүй тайлагнасан | 1 | 14,000.0 | 1 | 14,000.0 | | | 1 | 14,000.0 | | | | |
| **Дүн** | **7** | **673,158.2** | **1** | **14,000.0** | **6** | **659,158.2** | **7** | **673,158.2** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

*(мянган төгрөгөөр)*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 5,000.0 мянган төгрөг, бусад нийтлэг ажил үйлчилгээ төлбөр хураамжийн зардлаас 2,560.0 мянган төгрөг, мэдээллийн технологийн үйлчилгээний зардлаас 1,050.0 мянган төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийн зардлаас 396.0 мянган төгрөг, мөн барилгын засварын материал худалдан авахад 680.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлаас худалдан авахад 532.0 мянган төгрөгийг зарцуулж төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг зөрчсөн | 1 | 10,218.0 | | | 1 | 10,218.0 | | | | | | |
| Үзүүлсэн ажил, үйлчилгээ тодорхойгүй, анхан шатны баримтын бүрдэл хангагдаагүй байхад 8,340.0 мянган төгрөгийг зарцуулсан | 1 | 8,340.0 | | | 1 | 8,340.0 | | | | | | |
| Дээд шатны төсвийн захирагчаас автомашинд шаардлагатай урсгал засвар хийхэд зориулан олгосон 41,631.9 мянган төгрөгийн төсөвт өртгийг хувааж шууд худалдан авалт хийсэн | 1 | 41,631.9 | | | 1 | 41,631.9 | | | | | | |
| Бараа үйлчилгээний бусад зардлаас Түмэн тэмээний баярын арга хэмжээний медаль хийлгэхэд 3,000.0 мянган төгрөгийг нэхэмжлэх үндэслэн шилжүүлсэн | 1 | 3,000.0 | | | 1 | 3,000.0 | | | | | | |
| Тайлант онд 2,400.0 мянган төгрөгийн вирусийн программ худалдан авахдаа тус чиглэлээр үйл ажиллагаа явуулдаггүй аж ахуй нэгжээс худалдан авалт хийсэн | 1 | 2,400.0 | | | 1 | 2,400.0 | | | | | | |
| Тайлант хугацаанд нийт 64,242.8 мянган төгрөгийн өглөгтэй тайлагнасан | 1 | 64,242.8 | | | | | 1 | 64,242.8 | | | | |
| Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдлийг тулгахад ашиглалтын хугацаа дууссан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн нийт 22 нэр төрлийн 38 ширхэг 182,322.8 мянган төгрөгийн үлдэх өртөггүй хөрөнгө байна. | 1 | 182,322.8 | | | | | 1 | 182,322.8 | | | | |
| **Дүн** | **7** | **312,155.5** | | | **5** | **65,589.9** | **2** | **246,565.8** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

(мянган төгрөг)

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 2,474,109.8 мянган төгрөгийн санхүүжилтийг бөөн дүнгээр мэдээлсэн, 214,201.9 мянган төгрөгийн орлогыг мэдээлээгүй, зарлагын 351,466.9 мянган төгрөгийн гүйлгээг давхар мэдээлсэн, 56,317.9 мянган төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн 54 шийдвэрийг мэдээлээгүй | 1 | 3,096,096.5 | | | 1 | 3,096,096.5 | | |
| **ДҮН** | **1** | **3,096,096.5** | | | **1** | **3,096,096.5** | | |